Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 21.8 хувийг салхин цэцэг, 16.5 хувийг гар хөл амны өвчин, 12.4 хувийг цусан суулга, 11.4 хувийг тэмбүү, 8.6 хувийг сүрьеэ, 7.3 хувийг трихомониаз, 6.4 хувийг улаан эсэргэнэ, 6.3 хувийг заг хүйтэн, 1.1 хувийг вируст гепатит өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2017 оны X сарын танилцуулга

Хүснэгт 17. Нийслэлд гарсан халдварт өвчин, оны эхний 10 сард

Төрөл	Хэмжих нэгж	2015 I-X	2016 I-X	2017 I-X	Өсөлт, бууралт 2016-2017	
					тоо/пункт	Хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	бодит тоо	35698	35458	22 941	- 12 517	- 35.3
	10000 хүнд	276.6	266.6	168.3	- 98.3	
Үүнээс:						
Вируст гепатит	бодит тоо	424	286	262	- 24	- 8.4
	10000 хүнд	3.3	2.2	1.9	- 0.3	
Цусан суулга	бодит тоо	2027	2113	2 837	724	34.3
	10000 хүнд	15.7	15.9	20.8	4.9	
Салхин цэцэг	бодит тоо	2641	2507	5 000	2493	99.4
	10000 хүнд	20.5	18.8	36.7	17.9	
Гахай хавдар	бодит тоо	92	202	102	- 100	- 49.5
	10000 хүнд	0.7	1.5	0.7	- 0.8	
Сальмонеллэз	бодит тоо	86	136	133	- 3	- 2.2
	10000 хүнд	0.7	1.0	1.0	-	
Улаан эсэргэнэ	бодит тоо	383	964	1 467	503	52.2
	10000 хүнд	3.0	7.2	10.8	3.6	
Улаан бурхан	бодит тоо	18939	15962	7	- 15 955	- 100.0
	10000 хүнд	146.7	120.0	0.1	- 119.9	
Хоолны хордлого	бодит тоо	351	360	79	- 281	- 78.1
	10000 хүнд	2.7	2.7	0.6	- 2.1	
Ёлом	бодит тоо	85	100	154	54	54.0
	10000 хүнд	0.7	0.8	1.1	0.3	
Бруцеллэз	бодит тоо	15	16	28	12	75.0
	10000 хүнд	0.1	0.1	0.2	0.1	
Гар хөл амны өвчин	бодит тоо	1027	4344	3 779	- 565	- 13.0
	10000 хүнд	8.0	32.7	27.7	- 5.0	
Тэмбүү	бодит тоо	3436	2502	2 604	102	4.1
	10000 хүнд	26.6	18.8	19.1	0.3	
Заг хүйтэн	бодит тоо	1695	1604	1 455	- 149	- 9.3
	10000 хүнд	13.1	12.1	10.7	- 1.4	
Трихомониаз	бодит тоо	1466	1717	1 686	- 31	- 1.8
	10000 хүнд	11.4	12.9	12.4	- 0.5	
Сүрьеэ	бодит тоо	2226	2135	1 971	- 164	- 7.7
	10000 хүнд	17.3	16.1	14.5	- 1.6	
ДОХ	бодит тоо	10	19	23	4	21.1
	10000 хүнд	0.1	0.1	0.2	0.1	




## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны эхний 10 сард нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 26.1 мянган байгууллагын 606.9 мянган иргэд хамрагдаж нийгмийн даатгалын шимтгэл төлжээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийт иргэдийн 401.2 мянга буюу 66.1 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын, 115.2 мянга буюу 19.0 хувь нь төсөвт байгууллагын, 90.4 мянга буюу 14.9 хувь нь сайн дурын даатгуулагчид байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар буюу 20.5 мянган хүнээр нэмэгджээ.


Зураг 17. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагууд 2017 оны эхний 10 сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 110.8 хувиар биелүүлж, нийгмийн даатгалын санд нийт 677.5 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 62.7 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 20.3 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 7.3 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.0 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 1.7 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 18. Даатгалын сангийн зарлага



Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас оны эхний 10 сард даатгуулагч, иргэдэд 919.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгожээ. Нийт зардлын 68.6 хувийг тэтгэврийн, 16.9 хувийг эрүүл мэндийн, 6.1 хувийг ҮОМШӨ-ний, 6.2 хувийг тэтгэмжийн, 2.2 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.


Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 10 дугаар сард 159.1 мянгад, олгосон тэтгэврийн хэмжээ 537.2 тэрбум төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 75.6 хувийг өндөр насны, 10.3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.3 хувийг тэжээгчээ алдсаны, 10.8 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



## АЖ ҮЙЛДВЭР


Нийслэлийн аж үйлдвэрийн газрууд 2017 оны эхний 10 сард 6944.6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 7685.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 25.5 хувиар, борлуулалт 24.8 хувиар өссөн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэлт 6.2 хувиар, уул уурхайн олборлох үйлдвэрлэлт 27.5 хувиар, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 13.2 хувиар, боловсруулах үйлдвэрлэлт 29.0 хувиар тус тус өссөн байна.

Зураг 19. Аж үйлдвэрийн 2016-2017 оны үйлдвэрлэлт, борлуулалт, тэрбум төгрөг




Нийслэлийн аж үйлдвэрийн салбар 2017 оны 10-р сард 821.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхайн олборлох салбар 69.2 хувийг, цахилгаан дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэлт 8.7 хувийг, боловсруулах үйлдвэрлэлт 22.1 хувийг тус тус эзэлж байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын өсөлтөд хүнсний үйлдвэрлэлт, тамхи үйлвэрлэлт, нэхмэлийн үйлдвэрлэлт, хувцас үйлдвэрлэлт, арьс шир боловсруулах үйлдвэрлэлт, мод, модон эдлэл үйлдвэрлэлт, цаас цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэлт, эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэлт, тээврийн бусад хэрэгслийн үйлдвэрлэлт, мебель тавилга үйлдвэрлэлт болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт голлон нөлөө үзүүлсэн байна.


Зураг 20. Махны үйлдвэрлэлт, мянган тонн




Зураг 21. Гурил үйлдвэрлэлт, мянган тонн



Зураг 22. Талх, архи дарсны үйлдвэрлэлт




Зураг 23. Нүүрс олборлолт, мянган тонн




Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 3428.4 тэрбум төгрөгийг дотоодод, 4257.3 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна.

2017 оны эхний 10 сард борлуулсан нийт бүтээгдэхүүний 55.4 хувийг экспортоор гаргасан байна. Нийт экспортын 10.0 хувийг нүүрс олборлолт, 17.5 хувийг газрын тос шатдаг хий олборлолт, 45.5 хувийг төмрийн хүдэр олборлолт, 0.9 хувийг бусад ашигт малтмал олборлолт, 4.6 хувийг нэхмэлийн үйлдвэрлэлт, 0.3 хувийг арьс шир боловсруулах үйлдвэрлэлт, 0.6 хувийг хүнсний үйлдвэрлэлт, мод модон эдлэл, тамхи болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 20.6 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 24. Үйлдвэрлэлт, 2015-2017 он, тэрбум төгрөг



Зураг 25. Борлуулалт, 2015-2017 он, тэрбум төгрөг



Хүснэгт 18. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, өссөн дүн, оны үнээр

Салбар	Нийт бүтээгдэхүүн		
	2016 I-X	2017 I-X	$\frac{2017}{2016}$ %
	сая төгрөг		
<b>Бүгд</b>	<b>5 534 651.2</b>	<b>6 944 557.0</b>	<b>125.5</b>
<b>Уул уурхай, олборлолт</b>	<b>3 611 992.8</b>	<b>4 607 031.4</b>	<b>127.5</b>
Нүүрс олборлолт	311 047.8	794 391.3	2.6*
Газрын тос, шатдаг хий олборлолт	578 402.6	756 443.6	130.8
Төмрийн хүдэр олборлолт	2 664 797.8	2 985 127.8	112.0
Бусад ашигт малтмал олборлолт	57 744.6	71 068.7	123.1
<b>Боловсруулах үйлдвэрлэл</b>	<b>1 296 370.8</b>	<b>1 672 654.4</b>	<b>129.0</b>
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	725 919.2	821 630.1	113.2
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	60 647.3	80 745.9	133.1
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	50 038.5	87 565.7	175.0
Үр тарианы гурил, малын тэжээл	109 069.6	123 867.3	113.6
Хүнсний бусад бүтээгдэхүүн	84 198.9	100 642.1	119.5
Ундаа үйлдвэрлэл	421 964.9	428 809.1	101.6
Тамхи үйлдвэрлэл	14 835.5	18 932.4	127.6
Нэхмэлийн үйлдвэрлэл	336 186.2	346 792.3	103.2
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	8 044.0	12 714.1	158.1
Арьс шир боловсруулах үйлдвэр	7 614.5	16 326.2	2.1*
Мод модон эдлэл үйлдвэрлэл	6 511.2	9 827.6	150.9
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6 948.1	11 871.0	170.9
Хэвлэл болон дүү бичлэгийн үйл ажиллагаа	22 066.6	19 690.0	89.2
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	38 827.3	67 133.4	172.9
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	17 838.9	16 006.9	89.7
Төмөрлөг бүс эдлэлийн үйлдвэрлэл	29 957.7	37 438.2	125.0
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	952.3	1 107.5	116.3
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	2 284.2	2 901.5	127.0
Мебель тавилга үйлдвэрлэл, бусад үйлдвэрлэл	78 385.1	290 283.2	3.7*
<b>Цахилгаан, дулаан, усан хангамж</b>	<b>626 287.6</b>	<b>664 871.2</b>	<b>106.2</b>
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	589 311.3	624 406.4	106.0
Ус ариутгал, усан хангамж	36 976.3	40 464.8	109.4

\*дахин



Хүснэгт 19. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, өссөн дүн, оны үнээр

Салбар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2016 I-X	2017 I-X	$\frac{2017}{2016}$ %	Үүнээс: экспорт, %
	сая төгрөг			
<b>Бүгд</b>	<b>6 159 682.9</b>	<b>7 685 678.5</b>	<b>124.8</b>	<b>55.4</b>
<b>Уул уурхай, олборлолт</b>	4 183 058.1	4 598 266.4	109.9	68.5
Нүүрс олборлолт	314 531.1	529 688.3	168.4	80.4
Газрын тос, шатдаг хий олборлолт	563 381.0	746 618.7	132.5	100.0
Төмрийн хүдэр олборлолт	3 253 137.7	3 248 666.9	99.9	59.6
Бусад ашигт малтмал олборлолт	52 008.3	73 292.5	140.9	52.9
<b>Боловсруулах үйлдвэрлэл</b>	1 350 337.2	2 422 539.2	179.4	45.8
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	778 238.7	956 938.7	123.0	2.6
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	70 795.5	80 138.3	113.2	26.7
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	55 301.3	91 628.4	165.7	
Үр тарианы гурил, малын тэжээл	115 275.9	149 580.6	129.8	1.1
Хүнсний бусад бүтээгдэхүүн	85 863.8	112 139.3	130.6	
Ундаа үйлдвэрлэл	451 002.2	523 452.1	116.1	0.3
Тамхи үйлдвэрлэл	61 028.4	66 668.9	109.2	6.9
Нэхмэлийн үйлдвэрлэлт	297 116.0	308 967.8	104.0	63.3
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	9 817.4	12 939.4	131.8	
Арьс шир боловсруулах үйлдвэр	7 637.2	17 354.0	2.3*	61.9
Мод модон эдлэл үйлдвэрлэл	7 414.8	9 608.3	129.6	0.9
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6 978.8	12 039.6	172.5	
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	24 563.8	20 045.8	81.6	
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	43 098.5	74 174.2	172.1	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	17 846.5	16 360.6	91.7	
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	33 002.9	39 985.8	121.2	
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	922.1	1 342.2	145.6	
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	2 365.4	2 989.8	126.4	
Мебель тавилга үйлдвэрлэл, бусад үйлдвэрлэл	60 306.7	883 124.1	14.6*	98.9
<b>Цахилгаан, дулаан, усан хангамж</b>	626 287.6	664 872.9	106.2	
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	589 311.3	624 406.4	106.0	
Ус ариутгал, усан хангамж	36 976.3	40 466.5	109.4	

\* дахин



## ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ


2017 оны эхний 10 сард нийслэлийн хүн амд 30.1 сая.м<sup>3</sup> (78.1%), аж ахуйн нэгж, байгууллагад 8.5 сая.м<sup>3</sup> (21.9%) цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан усны нийт хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар өссөн байна.

Хүн амд түгээсэн цэвэр усны 96.2 хувь буюу 29.0 сая.м<sup>3</sup> усыг төвлөрсөн шугамаар, 1135.9 мян.м<sup>3</sup> (3.77%) усыг ус түгээх байраар, 8.1 мян.м<sup>3</sup> (0.03%) усыг тээврээр түгээсэн байна. Цэвэрлэх байгууламжаар 50.8 сая.м<sup>3</sup> бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 38.6 сая.м<sup>3</sup> бохир шингэнийг татан зайлуулсан байна.


Хүснэгт 20. Ус суваг ашиглалтын үйлчилгээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	$\frac{2017}{2016}$ %
Шахсан ус	мянган м <sup>3</sup>	44 806.7	43 592.5	43 663.3	43 665.2	100.0
Борлуулсан ус	мянган м <sup>3</sup>	37 636.7	37 281.2	37 082.6	38 600.0	104.1
Хүн амд	мянган м <sup>3</sup>	27 139.1	27 900.6	28 314.0	30 143.2	106.5
Аж ахуйн нэгж, байгууллагад	мянган м <sup>3</sup>	10 497.6	9 380.6	8 768.6	8 456.8	96.4
Татан зайлуулсан бохир	мянган м <sup>3</sup>	36 665.3	36 355.1	37 031.2	38 584.1	104.2
Хүн амаас	мянган м <sup>3</sup>	25 163.5	25 853.5	27 307.4	29 034.1	106.3
Аж ахуйн нэгж, байгууллагаас	мянган м <sup>3</sup>	11 501.8	10 501.6	9 723.8	9 550.0	98.2
Ус борлуулалтын орлого	сая төгрөг	16 162.7	21 852.8	21 498.6	23 385.0	108.8
Хүн амаас	сая төгрөг	8 967.4	12 808.7	12 836.4	13 710.9	106.8
Аж ахуйн нэгж, байгууллагаас	сая төгрөг	7 195.3	9 044.1	8 662.2	9 674.1	111.7
Сувагжуулалтын орлого	сая төгрөг	9 224.1	13 216.1	14 392.7	15 832.8	110.0
Хүн амаас	сая төгрөг	4 197.4	5 824.0	6 664.5	7 079.1	106.2
Аж ахуйн нэгж, байгууллагаас	сая төгрөг	5 026.7	7 392.1	7 728.2	8 753.7	113.3

Зураг 26. Борлуулсан ус, сараар, мян.м<sup>3</sup>



Зураг 27. Татан зайлуулсан бохир, сараар, мян.м<sup>3</sup>



### ГАЗАР ТАРИАЛАН

Ургац хураалтын мэдээгээр нийслэлийн хэмжээнд 204.2 га талбайгаас 1273.6 тонн төмс, 256.7 га талбайгаас 4030.6 тонн хүнсний ногоо хураан авч, 4108.4 тонн өвс хадлан, 722.1 тонн тэжээлийн ургамал бэлтгэсэн байна.


Хүснэгт 21. Ургац хураалт, тонн, эхний 10 сард

Дүүрэг	Төмс	Хүнсний ногоо	Үүнээс :		Өвс хадлан	Тэжээлийн ургамал
			Өргөст хэмх	Улаан лооль		
Нийслэлийн дүн	1 273.6	4 030.6	554.3	492.4	4 108.4	722.1
Багануур	151.1	95.0	7.4	1.8	1 374.2	92.0
Багахангай	8.2	5.5	0.5	0.2	362.0	-
Баянгол	9.0	258.7	133.7	116.5	-	-
Баянзүрх	52.6	73.5	13.7	11.2	474.0	-
Налайх	128.8	106.6	13.3	4.8	1 796.2	-
Сонгинохайрхан	677.3	1 208.6	214.6	270.0	-	630.1
Сүхбаатар	6.1	20.9	8.7	4.0	102.0	-
Хан-Уул	211.0	2 239.0	161.1	83.7	-	-
Чингэлтэй	29.5	22.8	1.3	0.2	-	-

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төмс 1453.6 (53.3%) тонноор, хүнсний ногоо 363.0 (8.3%) тонноор, өвс хадлан 6687.1 (61.9%) тонноор тус тус буурсан байна.

Нийслэлийн хэмжээнд хураан авсан нийт ургацын 24.8 хувийг Сонгинохайрхан дүүрэг, 24.2 хувийг Хан-Уул дүүрэг, 20.1 хувийг Налайх дүүрэг, 16.9 хувийг Багануур дүүрэг, 14.0 хувийг бусад дүүргүүд тус тус эзэлж байна.

Зураг 28. Ургац хураалт, тонн, эхний 10 сард




### АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2017 оны 10-р сард дунджаар  $+0.7^{\circ}\text{C}$  байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс  $+2.4^{\circ}\text{C}$ -аар, олон жилийн дундажтай харьцуулбал  $+0.1^{\circ}\text{C}$ -аар тус тус дулаан байв. Энэ сарын хамгийн дулаан хэм  $+17.7^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн хэм  $-10.8^{\circ}\text{C}$ , хур тунадасны нийлбэр 16.1 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 16 метр секунд хүрчээ.

Хүснэгт 22. Агаарын бохирдолт,  $\text{мг}/\text{м}^3$ , 10-р сард<sup>2</sup>

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO <sub>2</sub>	0.050	337	0.068	7	0.016
Азотын давхар исэл	NO <sub>2</sub>	0.050	300	0.450	64	0.040
Тоосжилт	PM <sub>10</sub>	0.100	280	0.308	164	0.123
	PM <sub>2.5</sub>	0.050	158	0.154	93	0.062
Нүүрстөрөгчийн дутуу исэл <sup>3</sup>	CO	10.000	770	5.363	-	1.022
Озон	O <sub>3</sub>	0.100	590	0.073	-	0.022

Зураг 29. Улаанбаатар<sup>4</sup> хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, 12 харуулын дундаж, сараар,  $\text{мг}/\text{м}^3$



<sup>2</sup> Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар


<sup>3</sup> 8 цагийн дундаж

<sup>4</sup> Багануур, Багахангай, Налайх дүүрэгт агаарын бохирдлыг хэмжих харуул цэг байхгүй.


2017 оны 10-р сард азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж Баруун 4 зам орчимд 31 удаа, 13-р хороолол орчимд 28 удаа, 32-ын тойрог болон Толгойт орчимд тус бүр 2 удаа, Амгалан орчимд 1 удаа, хүхэрлэг хийн агууламж Телевиз орчимд 6 удаа, Мишээл экспо төвийн орчимд 1 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Хархорин зах орчимд 27 удаа, Толгойт орчимд 23 удаа, 13-р хороолол болон Амгалан орчимд тус бүр 20 удаа, Баруун 4 зам орчимд 19 удаа, Нисэх болон Телевиз орчимд тус бүр 18 удаа, 32-ын тойрог орчимд 11 удаа, Мишээл экспо төвийн орчимд 7 удаа, Ургах наран хороолол орчимд 1 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгойт орчимд 24 удаа, Нисэх орчимд 17 удаа, Телевиз орчимд 16 удаа, Баруун 4 зам орчимд 14 удаа, 13-р хороолол орчимд 13 удаа, Амгалан орчимд 9 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.


Зураг 30. Улаанбаатар<sup>4</sup> хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, 12 харуулын дундаж, сараар, мг/м<sup>3</sup>



Зураг 31. Улаанбаатар<sup>4</sup> хотын агаар дахь нүүрстөрөгчийн дутуу исэл, 12 харуулын дундаж, сараар, мг/м<sup>3</sup>



Зураг 32. Улаанбаатар<sup>4</sup> хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 12 харуулын дундаж, сараар, мг/м<sup>3</sup>



Хүснэгт 23. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м<sup>3</sup>, 10-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруу- дын ордон	Хархорин зах	Ургах наран хороолол	Нисэх	Толгойт	Телевиз	Амгалан
Хүхэрлэг хий SO <sub>2</sub>	Дундаж	0.024	0.013	0.008	0.016	0.011	0.005	0.012	0.014	0.004	0.025	0.043	0.014
	Хамгийн их	0.053	0.036	0.019	0.036	0.032	0.017	0.027	0.026	0.009	0.047	0.068	0.033
	XXX*-с давсан хувь	4.0	-	-	-	-	-	-	-	-	-	40.0	-
	Хэмжилтийн тоо	25	31	31	31	31	31	31	30	26	27	15	28
Азотын давхар исэл NO <sub>2</sub>	Дундаж	-	0.101	0.029	0.078	0.037	0.024	0.035	0.033	0.012	0.033	0.032	0.028
	Хамгийн их	-	0.145	0.045	0.102	0.051	0.046	0.043	0.050	0.029	0.054	0.450	0.058
	XXX*-с давсан хувь	-	100.0	-	93.0	7.0	-	-	-	-	7.0	-	4.0
	Хэмжилтийн тоо	-	31	31	30	31	30	16	30	28	27	18	28
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	-	1.397	-	1.299	1.085	-	0.801	0.435	0.599	1.51	1.185	0.889
	Хамгийн их	-	5.363	-	3.763	2.738	-	2.225	4.620	1.273	3.131	3.576	3.496
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	79	-	90	93	-	93	90	83	81	77	84
Тоос PM <sub>10</sub>	Дундаж	0.084	0.125	-	0.132	0.095	-	0.171	0.068	0.123	0.169	0.136	0.131
	Хамгийн их	0.140	0.280	-	0.256	0.249	-	0.308	0.122	0.254	0.308	0.300	0.292
	XXX*-с давсан хувь	39.0	61.0	-	67.0	36.0	-	87.0	3.0	64.0	82.0	72.0	71.0
	Хэмжилтийн тоо	18	31	-	30	31	-	31	30	28	28	25	28
Тоос PM <sub>2.5</sub>	Дундаж	-	0.052	-	0.045	-	-	-	-	0.057	0.093	0.076	0.047
	Хамгийн их	-	0.127	-	0.071	-	-	-	-	0.096	0.150	0.154	0.088
	XXX*-с давсан хувь	-	48.0	-	50.0	-	-	-	-	61.0	89.0	80.0	32.0
	Хэмжилтийн тоо	-	29	-	26	-	-	-	-	28	27	20	28
Озон O <sub>3</sub> **	Дундаж	0.021	-	-	0.010	0.013	-	-	0.034	0.017	0.028	0.024	0.032
	Хамгийн их	0.037	-	-	0.030	0.044	-	-	0.065	0.034	0.066	0.073	0.051
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	43	-	-	82	74	-	-	84	83	81	59	84

\*- Хүлцэх хэм хэмжээ,

\*\* - CO, O<sub>3</sub>-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

**Туул голын усны бохирдол:**

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2017 оны 10-р сарын 4,5-ны өдрүүдэд хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 1.4 дахин, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд нитридийн нэгдэл 8.2 дахин, амоны азот 7.3 дахин, эрдэс фосфор, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч тус бүр 2.3 дахин хүлцэх хэм хэмжээнээс давж, Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 24. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м<sup>3</sup>, 10-р сард<sup>5</sup>

Үзүүлэлт	Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг		
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт	
Хүчилтөрөгч	O <sub>2</sub>	≥6	11.04	Хэвийн	7.84	Хэвийн
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	BХХ <sub>5</sub>	≤ 3	4.3	1.4 дахин	6.8	2.3 дахин
Нитридийн нэгдэл	NO <sub>2</sub>	≤ 0.02	0.002	Хэвийн	0.164	8.2 дахин
Амоны азот	NH <sub>4</sub>	≤0.5	0.04	Хэвийн	3.65	7.3 дахин
Эрдэс фосфор	P	≤0.1	-	-	0.229	2.3 дахин

**Байгаль орчны зөрчил:**

Нийслэлийн хэмжээнд 2017 оны эхний 10 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 251 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 38.2 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 35.8 хувийг газрын зөрчил, 8.0 хувийг геодези зураг зүй, кадастрын зөрчил, 7.6 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 4.8 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 2.0 хувийг ойн зөрчил, 1.2 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 2.4 хувийг бусад зөрчил тус тус эзэлж байна. Илрүүлсэн нийт зөрчилд 61.3 сая төгрөгийн торгууль ногдуулж, газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчлөөс 0.9 сая төгрөгийн нөхөн төлбөр төлөгджээ.

Хүснэгт 25. Байгаль орчны зөрчил, төрлөөр, эхний 10 сард

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2016			2017		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая.төг)	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая.төг)
Бүгд	146	166	57.0	375	251	61.3
Ой	15	10	3.8	8	5	2.2
Ан, амьтан	12	8	1.9	4	3	3.7
Газрын	11	37	25.3	197	90	43.6
Ус	7	-	1.1	1	-	-
Ургамал, хөрсний бохирдол	11	14	3.1	3	3	0.2
Агаар, химийн хорт бодис	11	21	5.0	11	12	1.0
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	18	17	5.5	96	96	6.0
Геодези зураг зүй, кадастр	12	27	1.4	9	20	3.4
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	6	-	-	35	19	1.0
Бусад	43	32	9.9	11	3	0.2

<sup>5</sup> Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори



## ГЭМТ ХЭРЭГ

2017 оны эхний 10 сард 17734 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2477 (16.2%) хэргээр өсчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 27.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 33.4 пунктээр доогуур байна. Гэмт хэргийн улмаас 4891 хүн гэмтэж осолдон, 459 хүн нас барж, төр ард иргэдэд 151.9<sup>б</sup> тэрбум төгрөгийн хохирол учруулсны 56.1 тэрбум (36.9%) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Зураг 33. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн 39.0 хувийг хулгайн, 24.0 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 11.6 хувийг залилан, 4.3 хувийг дээрмийн, 3.7 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг, 3.3 хувийг танхайн хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 26. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, төрлөөр, эхний 10 сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өсөлт, бүүралт, 2016-2017	
	2015 I-X	2016 I-X	2017 I-X	Тоо	Хувь
Хүний амь	90	67	81	14	20.9
Хүчин	111	121	168	47	38.8
Дээрэм	384	318	763	445	139.9
Хулгай	4 880	5 245	6 918	1 673	31.9
Булаалт	158	133	52	- 81	- 60.9
Залилан	1 469	1 635	2 049	414	25.3
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	3 930	4 141	4 253	112	2.7
Хөдөлгөөний аюулгүй байдал	934	799	650	- 149	- 18.6
ашиглалтын журам зөрчих					
Бусдыг амиа хорлоход хүргэх	105	115	381	266	231.3
Ашиглах	145	171	164	- 7	- 4.1
Танхайрах	1 049	1 029	578	- 451	- 43.8
Бусад	1 750	1 483	1 677	194	13.1
Бүгд	15 005	15 257	17 734	2 477	16.2

<sup>б</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 07-р сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дээрх хуулиудын өмнө мөрдөж байсан зарим заалт хүчингүй болсон тул өмнөх сараас хохирлын хэмжээ буурсан.



“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2017 оны X сарын танилцуулга

2017 оны эхний 10 сард 29910 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 11293 (27.4%) хүнээр буурсан байна.


Хүснэгт 27. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүргээр, эхний 10 сард

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2016-2017	
	2015 I-X	2016 I-X	2017 I-X	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	15 005	15 257	17 734	2 477	16.3
Багануур	270	251	220	- 31	- 12.3
Багахангай	21	20	32	12	60.0
Баянгол	2 392	2 704	2 434	- 270	- 10.0
Баянзүрх	3 622	3 519	4 793	1 274	36.2
Налайх	370	417	377	- 40	- 9.6
Сонгинохайрхан	2 685	2 440	3 196	756	31.0
Сүхбаатар	2 562	2 497	2 980	483	19.3
Чингэлтэй	1 919	2 028	2 215	187	9.2
Хан-Уул	1 164	1 381	1 487	106	7.7

Хүснэгт 28. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, эхний 10 сард

Дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс:	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
		Сэжигтнийг илрүүлж ял сонгосон	
Нийслэлийн дүн	14 151	3 912	27.6
Багануур	142	54	38.0
Багахангай	20	5	25.0
Баянгол	1 614	588	36.4
Баянзүрх	3 958	891	22.5
Налайх	246	62	25.2
Сонгинохайрхан	2 715	679	25.0
Сүхбаатар	2 580	683	26.5
Чингэлтэй	1 794	611	34.1
Хан-Уул	1 082	339	31.3

Зураг 34. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүргээр, эхний 10 сард



2017 оны эхний 10 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 10439 (58.9%) нь хөнгөн хэрэг, 3675 (20.7%) нь хүнд хэрэг, 3447 (19.4%) нь хүндэвтэр хэрэг, 173 (1.0%) нь онц хүнд хэрэг эзэлж байна.

Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь хамгийн өндөр (38.0%) нь Багануур дүүрэгт байгаа бол, хамгийн бага (22.5%) нь Баянзүрх дүүрэгт байна.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 7638 болж, өмнөх оны мөн үеэс 4645 хүнээр (37.8%) буурсан байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 1303 (17.1%) нь согтуугаар үйлдсэн, 975 (12.8%) нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 481 (6.3%) нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 410 (5.4%) нь хүүхэд, 1328 (17.4%) нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 29. Бүртгэгсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 10 сард

Дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо			Үүнээс:		
				Хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо		
	2015 I-X	2016 I-X	2017 I-X	2015 I-X	2016 I-X	2017 I-X
Нийслэлийн дүн	4 880	5 245	6 918	4 177	4 569	6 014
Багануур	63	63	64	49	51	53
Багахангай	2	3	5	1	2	2
Баянгол	535	735	600	436	603	459
Баянзүрх	1 294	1 294	2 119	1 119	1 101	1 819
Налайх	82	130	128	70	121	115
Сонгинохайрхан	1 058	838	1 397	967	763	1 277
Сүхбаатар	968	990	1 146	753	821	973
Чингэлтэй	590	790	943	510	742	844
Хан-Уул	288	402	516	272	365	472



## ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2017 оны эхний 10 сард 244 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 40.0 хувиар буурсан байна. Нийт гамшигт хүчтэй шороон шуурга 1, аадар бороо, үер 3, мал амьтны халдварт галзуу өвчин 4, үхрийн хорт салст хатуурал 1, хүний үйл ажиллагаатай холбоотой 235 осол бүртгэгдсэн байна.

Хүний үйл ажиллагаатай холбоотой осолд химийн бодисын 13 осол, усны 19 осол, барилгын 3 осол, бусад төрлийн 200 осол бүртгэгджээ. Гамшгийн улмаас 40 хүн амь насаа алдаж, 215 хүнийг аварч, гамшгийн үршгийг арилгах ажилд нийт 94.2 сая төгрөг зарцуулжээ.

Нийслэл хотод 2017 оны эхний 10 сард ахуйн 2087 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар буурсан байна. Гал түймрийн улмаас 18 хүн (үүнээс, хүүхэд 5) амь насаа алдаж, 22 хүн (үүнээс, хүүхэд 9) түлэгдэж гэмтсэн байна.


Хүснэгт 30. Гал түймрийн тоо, дүүргээр, жил бүрийн эхний 10 сард

Дүүрэг	2012	2013	2014	2015	2016	2017	$\frac{2017}{2016}$ %
Нийслэлийн дүн	2031	2343	2317	2852	2103	2087	99.2
Багануур	22	27	29	42	39	28	71.8
Багахангай	4	2	6	9	7	3	42.9
Баянгол	286	381	350	382	354	306	86.4
Баянзүрх	476	517	556	684	516	481	93.2
Налайх	85	84	94	70	81	71	87.7
Сонгинохайрхан	371	470	443	622	453	465	102.6
Сүхбаатар	325	321	349	402	239	282	118.0
Хан-Уул	176	211	225	279	186	215	115.6
Чингэлтэй	286	330	265	362	228	236	103.5


Гал түймрийн аюулаас 667 хүн, 821 байшин барилга, 2.5 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал, цахилгаанаас 196, санамсаргүй байдлаас 1437, санаатай үйлдлээр 1, шалтгаан тогтоогдоогүй 99, бусад шалтгаанаар 354 гал түймэр гарчээ.

Гал түймэрт 667 гэр, орон сууц, 261 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 108 машин техник, малын 187 хашаа, саравч, бусад төрлийн 864 объект өртсөн байна. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 1207, төрийн өмчийн 615, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 265 объект өртөж, нийт 4.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Зураг 35. Гал түймэр, байршлаар



Зураг 36. Гал түймэр, шалтгаанаар



Нийслэлийн Онцгой байдлын газраас 2017 оны эхний 10 сард 207 барилгын зураг төсөл, мөн ашиглалтад хүлээн авч буй 211 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 5539 айл өрх, 8284 объектод үзлэг шалгалт хийж, 41869 галын зөрчил илрүүлж, 71 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 2220 заавал биелүүлэх албан шаардлага, 2969 мэдэгдэл хүргүүлж, 75.7 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.




### ДОТООД ХУДАЛДАА

Жилд дунджаар 50.0 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж байгууллагууд худалдааны салбарын 10.0 гаруй хувийг эзэлж байгаа хэдий ч салбарын нийт борлуулалтын орлогын 90.0 гаруй хувь нь эдгээр нэгжид ногдож байна.

2017 оны эхний 9 сард бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт улсын хэмжээд 10194.7 тэрбум төгрөгт хүрснээс 9375.4 тэрбум төгрөгийн (91.2%) борлуулалтыг нийслэл хот дангаараа гүйцэтгэсэн байна.

Зураг 37. Дотоод худалдааны борлуулалт, 2015-2017 он, тэрбум төгрөг



Нийслэл Улаанбаатар хотод 2017 оны эхний 9 сард 9375.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1719.8 тэрбум төгрөгөөр (22.5%) өссөн байна.